



ТӨВ АЙМГИЙН  
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/07

Зуунмод

Золбин нохой, муур устгах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Галт зэвсгийн тухай хуулийн нэгдүгээр бүлгийн 10.2, Зуунмод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Журам батлах тухай” 28 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зуунмод сумын нутаг дэвсгэрт эзэнгүй золбин нохой, муур устгах ажлыг 2023 оны 1 дүгээр улирлаас эхлэн зохион байгуулж явуулахыг Хот тохижуулах газрын дарга (А.Шаравнямбуу)-д даалгасугай.

2.Хот тохижуулах газрын дарга (А.Шаравнямбуу)-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

2.1.Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд 2023 онд төлөвлөсөн хугацаанд эзэнгүй золбин нохой, муурыг цөөлөх ажлыг зохион байгуулахад Багийн Засаг дарга, хэсгийн ахлагч, хэсгийн байцаагч, иргэдийг хамруулж ажиллах.

2.2.Нохой, муур устгах ажлыг эрх бүхий иргэн, байгууллагатай гэрээ байгуулан аюулгүй ажиллагаанд зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулсаны үндсэн дээр орчны аюулгүй байдлыг дээд зэргээр хангаж, Хот тохижуулах газрын албан тушаалтны хяналт, удирдлага дор шуурхай хэрэгжүүлэх.

2.3.Нохой, муур устгаж буй эрх бүхий иргэнийг тусгай хувцас хэрэглэлтэй байх, халдвараас сэргийлж машин техник, багаж хэрэгслээ байнга ариутгаж хэрэглэх, шаардлагатай газруудыг ариутгаж зориулалтын газарт булаах ажилд хяналт тавьж ажиллахыг сумын Байгаль орчны мэргэжилтэн (О.Одням)-д даалгах.

2.4.Нутаг дэвсгэрийн хэмжээнд эзэнгүй золбин нохой, муур устгах арга хэмжээг зохион байгуулж буй ажлыг аймгийн Цагдаагийн газарт болон олон нийтэд тодорхой мэдээлж, аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

3.Багийн Засаг дарга нарт ДААЛГАХ нь:


3.1.Багийнхаа нутаг дэвсгэрт золбин нохой, муур устгах арга хэмжээ зохион байгуулж байгаа талаар иргэдэд зарлан мэдэгдэж, гэрийн тэжээвэр нохойгоо байнга уяж байхыг анхааруулах арга хэмжээ авах.

3.2.Багийн нутаг дэвсгэрт байгаа эзэнгүй нохой, муурыг зааж өгөх, газарчлах хүн тусгайлан гаргаж өгч, устгалын ажилд хяналт тавьж, Хот тохижуулах газартай хамтран ажиллах.

3.3.Багийнхаа нутаг дэвсгэрээс эзэнгүй золбин нохой, муурыг устгасан тоог үнэн зөв гаргаж, захирагчийн албанд албан ёсоор ирүүлэх.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг улирал бүр сумын Засаг даргад танилцуулахыг Засаг даргын орлогч (Н.Энхсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.САРАНГЭРЭЛ